



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1/64

Мандалговь.

Мөнгөн урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 55 дугаар зүйлийн 55.2, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.11.2-ын "Б", 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3, 2.4, газрын даргын 2020 оны А/33 тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албан хаагчдын 2020 оны III улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд үндэслэн "Хангалттай" үнэлэгдсэн албан хаагчдад хавсралтын дагуу мөнгөн урамшуулал олгосугай.

2. Албан хаагчдад олгох урамшуулал 4758166 (Дөрвөн сая долоон зуун тавин найман мянга нэг зуун жаран зургаа) төгрөгийг нэмэгдэл цалин хөлснөөс тооцож олгохыг газрын Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн, хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэн, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190170

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
орны дугаар сарын өдрийн
дугаар тушаалын дүгээр хавсралт



УРАМШУУЛАЛ ОЛГОХ
АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Үндсэн цалин	Үнэлгээний хувь	Урамшууллын дүн
1	Р.Мөнхбат	Захиргаа, хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	773046	90.7	280460
2	Х.Мөнхсаруул	Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	754867	94.1	284131
3	Ш.Эрдэнэсүвд	Залуучууд, хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн	642388	92	236398
4	Б.Цэцэг	Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн	680286	95.3	259324
5	С.Чинбат	Нягтлан бодогч	797676	95	303116
6	Б.Бүжинлхам	Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	625965	90.7	227100
7	Х.Төмөрбат	Залуучуудын салбар зөвлөлийн нарийн бичиг	562911	80.2	180581
8	Л.Цэвэлмаа	Парк, зуслангийн нярав	538350	96	206726
9	М.Чулуунбаатар	Жижүүр, мужаан	523405	90	188425
10	Б.Мөнх-Оргил	Архив бичиг хэрэг, олон нийт хариуцсан ажилтан	562911	92	207150
11	Б.Гансүх	Паркийн жолооч, операторчин	489168	82.7	161816
12	Г.Оюунбилэг	Хамгаалах байрны арга зүйч	625965	86	215331
13	Э.Мөнхдалай	Нярав	524696	88.7	186161
14	Ц.Идэр-Оргил	Паркийн захирал	720845	81.6	235283
15	Ё.Аюур	Паркийн сахиул	467374	85.7	160215
16	Ш.Эрдэнэбат	Паркийн цахилгаанчин	467374	80	149559
17	Ц.Сумьяабазар	Зуслангийн сахиул	478742	90	172346
18	Ш.Энх-Амгалан	Туслах ажилтан	467374	90	168254
19	Э.Шинэхүү	Хамгаалах байрны гэрээт ажилтан	625965	90	225347
20	Д.Саранзаяа	Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан	562911	80.2	180581
21	Э.Нандинчулуун	Үйлчлэгч	478742	85.5	163729
22	Ж.Бархас	Жижүүр, цахилгаанчин	523405	90	188425
23	С.Доржнамжил	Жижүүр, сантехникч	478742	92.8	177708
Нийт дүн					4 758 166

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР